(몽골어)

<Корона19 вирусын эсрэг вакцин тариулсны дараах зааварчилгаа-1>

○ **Вакцин тариулах өдөр**

- Биеийн эрүүл мэндийн байдал сайн байх үедээ вакцин хийлгэх/-нарийвчилсан үзлэг / -аюулгүй вакцинжуулалт

○ **Вакцин тариулсны дараа**

-Вакцин тарьсан байгууллага дээр түр байж, гаж нөлөө илэрч буй эсэхийг хянах

○ **Корона вирусын эсрэг вакцин тариулсны дараа анхаарах зүйлс.**

*Вакцин тариулсны дараа 15~30минутын турш хяналтын өрөөнд сөрөг урвалын шин ж тэмдэг илрэх эсэхийг ажиглах.

- Онцгойлох харшил байхгүй бол, вакцин тариулсны дараа 15минут ажиглана.
- Хэрэв өмнө нь харшилтай байсан бол, 30минутын турш заавал ажиглалт хийнэ.

*Гэртээ очсоны дараа 3-н цагийн турш биеийн байдлаа хянаж сөрөг урвалын шинж т эмдэг илрэх эсэхийг ажиглана.

*Вакцин тариулсны дараа 3-н өдрийн турш онцгойлох шинж тэмдэг илрэх эсэхийг ан хааралтай ажиглана.

*Вакцин тариулсан өдөр ба дараагийн өдөр хүчний дасгал мөн согтууруулах ундаана ас зайлс хийнэ үү.

*Вакцин тариулсан өдөр усанд орохгүй байвал сайн.

*Вакцин тариулсан хэсгийг цэвэр байлгана уу.

*Өндөр настан вакцин тариулсны дараа хэн нэгэнтэй хамт байж шинж тэмдэг илэрсэ н тохиолдолд тусламж авна уу.

Корона19 вакцин болон урьдчилан сэргийлэх тарилгатай холбоотой мэдээллийг корона19вакцин.kr (코로나19예방접종.kr**) вебсайтаас шалгана уу!**

<Корона19 вирусын эсрэг вакцин тариулсны дараах зааварчилгаа-2>

○ **Вакцин тариулсны дараа сөрөг урвал.**

▸**Вакцин тариулсны дараа гарч буй нийтлэг шинж тэмдэг.**

Вакцин тариулсны дараа доорхын адил нийтлэг шинж тэмдэг илрэх магадлалтай. Энэ нь дар хлаа тогтох явцад илэрдэг ба ихэвчлэн 2~3өдрийн дотор хэвийн байдалдаа эргэн орно.

- Тарилга хийлгэсэн хэсэг өвдөх, хавдах, таталт өгөх / - халуурах, дотор муухайрах, булчин ө вдөх / - ядрах / - толгой өвдөх.

▸**Вакцин тариулсны дараа доорхын адил шинж тэмдэг илэрвэл.**

- Тарилга хийлгэсэн хэсэг хавдах·өвдөх тохиолдолд цэвэр алчуураар мөсөн жин тавина уу.
- Бага зэрэг халуурвал шингэн зүйл ус хангалттай ууж сайн амарна уу.
- Бүх бие өвдөж биеийн халуун тогтворгүйжиж, тамирдах байдалд орвол халуун буулгах эм·өвчин намдаагч ууж болно.
- Вакцин тариулахын өмнө урьдчилаад халуун буулгах эм·өвчин намдаагчийг бэлдээд, шинж тэмдэг илэрвэл эмээ хэрэглэнэ. Халуун буулгах·өвчин намдаах эмийг хэрэглэх хязгаар байхг үй ч болж өгвөл үрэвсэл дарахад хүчтэй нөлөөлөхөөргүй Ацетаминофены орцтой эмийг хэрэ глэхийг зөвлөж байна.

▸**Корона19 вирусын эсрэг вакциныг тариулсны дараа сөрөг урвалын шинж тэмдэг ил рэх тохиолдолд.**

Ихэвчлэн халуун буулгах • өвчин намдаах эм хэрэглэхэд шинж тэмдэг арилах ба, 2-оос дээш өдөр тарилга хийлгэсэн хэсэг хавдах, өвдөх, таталт өгөх зэрэг шинж тэмдэг үргэлжлэн илэрв эл эмчид хандаж эмчилгээ хийлгэнэ үү.

Хэрэв амьсгалын дутагдалд орох, ухаан алдах, нүүр хавагнах мэт шинж тэмдгүүд хоршсон х урц харшил(Анафилакс)илэрвэл яаралтай 119 дугаарт залгаж тусламж хүсэх ба ойрхон эмнэл гийн түргэн тусламжийн тасагт очихыг зөвлөж байна.

+Вакцин тариулсны дараа биеийн байдлыг хянах **https://nip.kdca.go.kr**

+Вакцин тариулсны дараа сөрөг урвал илэрвэл мэдэгдэх **https://nip.kdca.go.kr**

+Урьдчилан сэргийлэх вакцины вебсайт**(https://nip.kdca.go.kr)**ын тусламжтайгаар вакцин та риулсны дараа өөрийнхөө шинж тэмдэгийг шалган, хянах зааварчлага авах боломжтой.

<Орчуулгыг Данүри 1577-1366 хийв>